5

БАТЛАВ. "УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БЯМБА-ОЧИР

БАТЛАВ. "ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-2" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ү.ТӨМӨРХУЯГ

ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ГЭРЭЭ

2012 оны 01 дугаар сарын 01-ны өдөр | Дугаар 2012/87 | Улаанбаатар хот

Нэг талаас "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК /цаашид "Зээлдүүлэгч" буюу "УБДС" ТӨХК гэх/, түүнийг төлөөлж ерөнхий нягтлан бодогч И.Шүрэнцэцэг нөгөө талаас "Дулааны цахилгаан станц-2" ТӨХК /цаашид "Зээлдэгч" буюу ""ДЦС-2" ТӨХК гэх/ түүнийг төлөөлж ерөнхий нягтлан бодогч М.Мандах нар Монгол Улс ба Азийн хөгжлийн банкны хооронд 1997 оны 8 дугаар сарын 11-ний өдөр байгуулагдсан Зээлийн хэлэлцээр, "Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2010 оны 72 дугаар тогтоол, "Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2006 оны 141 дүгээр тогтоол, "Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2009 оны 20 дугаар тогтоол, "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2009 оны 284 дүгээр тогтоол, "Журам батлах тухай" Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам", "Төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын 2011 оны 139 дүгээр тогтоол, "Тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Сангийн сайд, Эрдэс, баялаг, эрчим хүчний сайдын хамтарсан 2011 оны 276/300 дугаар тушаалыг тус тус үндэслэл болгон "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК, "Дулааны цахилгаан станц-2" ТӨХК-ийн хооронд 2007 оны 03 дугаар сарын 20-ны өдөр байгуулагдсан "Дулааны үр ашгийн төсөл"-ийн "1548 MON(SF)" тоот гэрээг дор дурьдсан дүн, нөхцөлөөр шинэчлэн байгуулахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2012 оны дугаар сарын -ны өдөр шинэчилэн байгуулав.

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

(А) "УБДС" ТӨХК, "ДЦС-2" ТӨХК -ийн хооронд 2007 оны 03 дугаар сарын 20–ны өдөр байгуулсан Зээлийн гэрээнд тусгагдсан нөхцөл, болзолын дагуу зээлдүүлэгч нь зээлдэгчид 749309,54 /Долоон зуун дөчин есөн мянга гурван зуун есөн ам.доллар тавин дөрвөн цент/ ам.долларын зээлийг дамжуулан зээлдүүлэхийг зөвшөөрсөн.

(Б) Засгийн газрын шугамаар авсан гадаадын зээлийг эргүүлэн төлөх дотоод эх үүсвэрийг бүрдүүлэх /Зээлийн хэлэлцээрт тодорхойлсоны дагуу "Дулааны үр ашгийн төсөл" /цаашид "Төсөл" гэнэ/-ийг хэрэгжүүлэхэд зориулан зээлдэгчид энэ гэрээнд заасан нөхцөл болзолын дагуу зээлийн хөрөнгөнөөс дамжуулан зээлдүүлэхээр Сангийн яамнаас шийдвэрлэсэн.

(В) Зээлийн хэлэлцээр болон "Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам"-д тодорхойлогдсон нэр томъёо нь утга агуулгын хувьд тухайн баримт бичгүүдэд тодорхойлсон тэрхүү утга агуулгаа энэ Дамжуулан зээлдүүлэх гэрээнд мөн адил хадгална.

Энэ гэрээний аливаа хавсралт нь түүний салшгүй хэсэг байна.

## НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ
## ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ НӨХЦӨЛ

1.1. "УБДС" ТӨХК-аас энэ гэрээний 2 дугаар зүйлд заасан нөхцөл болзолын дагуу зээлдэгчид дамжуулан зээлдүүлсэн зээлийн төгрөгөөр илэрхийлсэн нийт дүн нь 830047642,93 /Найман зуун гучин сая дөчин долоон мянга зургаан зуун дөчин хоёр төгрөг ерэн гурван мөнгө/ төгрөг байна.

1.2. Зээлдэгчийн нэр, байнгын хаяг:

"Дулааны цахилгаан станц-2" ТӨХК

| | |
|---|---|
| Улсын бүртгэлийн дугаар: | 9012001006 |
| Регистрийн дугаар: | 2664623 |
| Утасны дугаар: | 632167, факс: 632177 |
| Хаяг: | Баянгол дүүрэг, Дунд гол, 20-р хороо |

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ
## ХҮҮГИЙН ХУВЬ БОЛОН ҮНДСЭН ТӨЛБӨРИЙГ ЭРГҮҮЛЖ ТӨЛӨХ НӨХЦӨЛ

2.1 Зээлдэгч нь ашигласан зээлийн өрийн үлдэгдэлд 1999.06.15-2032.06.15 хүртэлх хугацаанд жилийн 2.00 % /хоёр хувь/–тай тэнцэх хүүг төгрөгөөр тооцож тогтоосон хугацаанд "УБДС" ТӨХК-нд төлнө.

2.2 Хүүгийн төлбөрийг хагас жил тутам буюу жил бүрийн 06 дугаар сарын 15-ны, 12 дугаар сарын 15-ний өдөр тус тус төлөх бөгөөд хүүг жилийн 360 хоногоор, сарын 30 хоногоор тооцно.

2.3 Зээлдэгч нь зээлийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн төлбөрийг 26 жилийн хугацаанд төлөх бөгөөд анхны төлбөрийг 2005 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн жил бүрийн 06 дугаар сарын 15-ны өдөр, 12 дугаар сарын 15-ны өдөр энэхүү гэрээний хавсралтад заасан төлбөрийн хуваарийн дагуу "УБДС" ТӨХК-нд төлнө.

2.4 Зээлийн хэлэлцээрт энэхүү төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа хураамж төлөх үүргийг Монгол Улс хүлээсэн бол зээлдэгч нь төлбөрийг тухайн үеийн ханшаар "УБДС" ТӨХК-нд төлөх болно.

2.5 Зээлдэгч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг "УБДС" ТӨХК-ийн Худалдаа хөгжил" –Богдхан салбар банкны 406005907 тоот төгрөгийн дансанд шилжүүлэх бөгөөд нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу дансны хуулгыг үндэслэн бүртгэл тооцоог хөтөлнө. Төлбөрийн даалгаврын зориулалт гэсэн хэсэгт зээлийн "Үндсэн өрийн төлбөр" эсвэл "Хүүгийн төлбөр" гэж тодорхой бичсэн байна.

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ
## "УБДС" ТӨХК-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Энэхүү гэрээний аливаа заалтыг харгалзахгүйгээр Зээлийн хэлэлцээрийн дагуу төсөлд зориулж хөрөнгө шилжүүлж авах "УБДС" ТӨХК-ийн эрх бүхлээр буюу хэсэгчлэн зогсох, цуцлагдах эсхүл дуусгавар болох тохиолдолд

зээлдэгчийн зээлийн хөрөнгө хүлээн авах эрх нэгэн адил зогсох, цуцлагдах эсхүл дуусгавар болно.

3.2 Зээлдэгч Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцож, үл маргалдах журмаар Зээлдэгчийн Худалдаа хөгжлийн банк дахь "458011091 тоот данснаас төлбөрийг гаргуулах эрхтэй.

3.3 Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг дор дурдсан дараалаар хасалт хийж тооцно. Үүнд:

1. Алданги
2. Хүүгийн төлбөр
3. Үндсэн төлбөр

3.4 Зээлдэгч зээлийг зориулалт бусаар ашигласан, зээлийн төлбөрийг Дамжуулан зээлдүүлэх гэрээнд заасан хугацаанд эргүүлэн төлөөгүй болон "Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам", Зээлийн хэлэлцээр, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд зээлийг хэсэгчлэн эсвэл бүрэн хэмжээгээр зогсоох, төсөл хэрэгжүүлэх эрхийг түдгэлзүүлэх, холбогдох албан тушаалтанд хариуцлага ногдуулах, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.5 Зээлдэгч гуравдагч этгээдтэй дамжуулан зээлдэх давхар гэрээ байгуулах эсэхээс үл хамааран дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг гагцхүү зээлдэгчээр төлүүлнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ
## ЗЭЭЛДЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Зээлдэгч нь энэ гэрээний Ерөнхий зүйлийг (Б)-д заасан төслийг удирдлага, зохион байгуулалт, санхүү, инженер техник, байгаль орчин болон олон улсын стандартын хэм хэмжээний хүрээнд үр ашигтай хэрэгжүүлэх үүрэгтэй.

4.2 Зээлдэгч нь Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон хөрөнгийг зөвхөн Зээлийн хэлэлцээрт заасан төслийн зориулалтаар ашиглана.

4.3 Зээлийн данснаас шилжүүлсэн төлбөрийг хүлээн авах тухай бүрт бодитоор гарсан зардлын үндсэн баримтыг үндэслэн бүртгэл тайланд тусгана.

4.4 Зээлдэгчийн зээлийн хөрөнгөөр авсан эд хөрөнгө нь төрийн өмчид хамаарах бөгөөд Дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болох хүртэл тайлан тэнцэлдээ өглөг хэлбэрээр тусгаж бүртгэнэ.

4.5 Зээлдэгч нь зээлийн хөрөнгөөр олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй бөгөөд эд хөрөнгийг захиран зарцуулахыг хориглоно.

4.6 Зээлдэгч нь үндсэн болон хүүгийн төлбөр хийсэн тухай бүр "УБДС" ТӨХК-нд мэдэгдэж улирал бүр тооцоо нийлж баталгаажуулах үүрэгтэй.

4.7 Хэрэв зээлдэгч үүсгэн байгуулсан зорилтот үйл ажиллагаагаа зогсоох, татан буугдах зэрэг тохиолдолд дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн өрийн төлөгдөөгүй үлдэгдэл, тухайн үед хуримтлагдсан бүх хүүг нэн даруй "УБДС" ТӨХК-нд төлнө.

4.8 Зээлдэгч дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалтын явцын талаарх тайлан танилцуулгыг хагас, бүтэн жилээр гаргаж, зээлийн шугамаар нийлүүлэгдэх тоног, төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалыг хүлээн авсан нийлүүлэлт, үлдэгдлийн мэдээ, тайланг тухай бүр зээлдэгчид ирүүлнэ.

## ТАВДУГААР ЗҮЙЛ
## МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

5.1 Сангийн яам, зээлдэгчийн хооронд гарсан аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд хэрэв ийм шугамаар шийдвэрлэх боломжгүй бол маргааныг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

## ЗУРГААДУГААР ЗҮЙЛ
## ХҮЧИН ТӨГӨЛДӨР, ДУУСГАВАР БОЛОХ

Энэхүү шинэчилсэн гэрээ нь оролцогч талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

Сангийн яам холбогдох яам, газартай энэхүү гэрээг дүгнэж, зээлдэгч уг зээлтэй холбогдох ямар нэг өр төлбөргүй болохыг тодорхойлсон эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргаж, зээлийг хаасан тухай Сангийн яамны мэдэгдлийг зээлдэгчид хүргүүлсэнээр уг Дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болсонд тооцно.

Зээлдэгч нь өөрчлөн байгуулагдах тохиолдолд зээлдэгчийн Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг нь ийнхүү өөрчлөн байгуулагдсаны дүнд шинээр үүссэн хуулийн этгээдэд шилжинэ.

Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа дамжуулан зээлдүүлсэн зээлийн өр төлбөрийг тайлан балансад зайлшгүй тусгана.

Энэ гэрээ байгуулсантай холбогдуулан зээлдэгч, зээлдүүлэгчийн хооронд өмнө нь байгуулагдсан дараахь гэрээнүүдийг хүчингүй болсонд тооцно. Үүнд:

- "УБДС" ТӨХК, "ДЦС-2" ТӨХК -ын хооронд оны 2004 оны 07 дугаар сарын 19-ны өдөр байгуулагдсан 1548 MON(SF) дугаартай "Дулааны үр ашгийн төсөл"-ийн дамжуулан зээлдэх гэрээ";
- "УБДС" ТӨХК, "ДЦС-2" ТӨХК -ын хооронд 2007 оны 03 дүгээр сарын 20-ны өдөр байгуулагдсан 1548 MON(SF) дугаартай "Дулааны үр ашгийн төсөл"-ийн дамжуулан зээлдэх гэрээ";
- "УБДС" ТӨХК, ""ДЦС-2" ТӨХК хооронд 2010 оны .... дугаар сарын ....-ны өдөр байгуулагдсан "2007 оны 03 дүгээр сарын 20-ны өдөр "УБДС" ТӨХК ба "ДЦС-2" ТӨХК хооронд байгуулсан 1548 MON(SF) тоот Дамжуулан зээлдүүлэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ".

**САНГИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ:**

"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

И.ШҮРЭНЦЭЦЭГ

**ЗЭЭЛДЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-2" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

М.МАНДАХ

н 2010 оны 72 дугаар тогтоолын хүрээнд Улаанбаатар Дулаааны Сүлжээ ТӨХК болон Дулааны гаан Станц-2 ТӨХК-ийн хооронд байгуулсан 1548-MON(SF) дугаартай дамжуулан зээлдүүлэх гэрээний хавсралт

гэн төлөх хуваарь

Хүү 2%

| *Тайлант хугацаа* | *Хоног* | *Хүүгийн төлбөр/төг/* | *Үндсэн төлбөр* | *Нийт* | *Зээлийн үлдэгдэл* |
|---|---|---|---|---|---|
| 15/Dec/2011 | | | | | |
| 15/Jun/2012 | | 8,414,703.69 | 10,622,872.39 | 19,037,576.08 | 733,660,067.12 |
| 15/Dec/2012 | 180 | 8,308,474.97 | 10,622,872.39 | 18,931,347.35 | 723,037,194.74 |
| 15/Jun/2013 | 180 | 8,202,246.24 | 10,622,872.39 | 18,825,118.63 | 712,414,322.35 |
| 15/Dec/2013 | 180 | 8,096,017.52 | 10,622,872.39 | 18,718,889.90 | 701,791,449.97 |
| 15/Jun/2014 | 180 | 7,989,788.80 | 10,622,872.39 | 18,612,661.18 | 691,168,577.58 |
| 15/Dec/2014 | 180 | 7,883,560.07 | 10,622,872.39 | 18,506,432.46 | 680,545,705.20 |
| 15/Jun/2015 | 180 | 7,777,331.35 | 10,622,872.39 | 18,400,203.73 | 669,922,832.81 |
| 15/Dec/2015 | 180 | 7,671,102.62 | 10,622,872.39 | 18,293,975.01 | 659,299,960.43 |
| 15/Jun/2016 | 180 | 7,564,873.90 | 10,622,872.39 | 18,187,746.29 | 648,677,088.04 |
| 15/Dec/2016 | 180 | 7,458,645.18 | 10,622,872.39 | 18,081,517.56 | 638,054,215.66 |
| 15/Jun/2017 | 180 | 7,352,416.45 | 10,622,872.39 | 17,975,288.84 | 627,431,343.27 |
| 15/Dec/2017 | 180 | 7,246,187.73 | 20,560,287.16 | 27,806,474.89 | 616,808,470.89 |
| 15/Jun/2018 | 180 | 7,040,584.86 | 20,560,287.16 | 27,600,872.02 | 596,248,183.73 |
| 15/Dec/2018 | 180 | 6,834,981.99 | 20,560,287.16 | 27,395,269.15 | 575,687,896.56 |
| 15/Jun/2019 | 180 | 6,629,379.11 | 20,560,287.16 | 27,189,666.28 | 555,127,609.40 |
| 15/Dec/2019 | 180 | 6,423,776.24 | 20,560,287.16 | 26,984,063.40 | 534,567,322.24 |
| 15/Jun/2020 | 180 | 6,218,173.37 | 20,560,287.16 | 26,778,460.53 | 514,007,035.08 |
| 15/Dec/2020 | 180 | 6,012,570.50 | 20,560,287.16 | 26,572,857.66 | 493,446,747.91 |
| 15/Jun/2021 | 180 | 5,806,967.63 | 20,560,287.16 | 26,367,254.79 | 472,886,460.75 |
| 15/Dec/2021 | 180 | 5,601,364.76 | 20,560,287.16 | 26,161,651.92 | 452,326,173.59 |
| 15/Jun/2022 | 180 | 5,395,761.88 | 20,560,287.16 | 25,956,049.05 | 431,765,886.43 |
| 15/Dec/2022 | 180 | 5,190,159.01 | 20,560,287.16 | 25,750,446.18 | 411,205,599.26 |
| 15/Jun/2023 | 180 | 4,984,556.14 | 20,560,287.16 | 25,544,843.30 | 390,645,312.10 |
| 15/Dec/2023 | 180 | 4,778,953.27 | 20,560,287.16 | 25,339,240.43 | 370,085,024.94 |
| 15/Jun/2024 | 180 | 4,573,350.40 | 20,560,287.16 | 25,133,637.56 | 349,524,737.78 |
| 15/Dec/2024 | 180 | 4,367,747.53 | 20,560,287.16 | 24,928,034.69 | 328,964,450.61 |
| 15/Jun/2025 | 180 | 4,162,144.65 | 20,560,287.16 | 24,722,431.82 | 308,404,163.45 |
| 15/Dec/2025 | 180 | 3,956,541.78 | 20,560,287.16 | 24,516,828.95 | 287,843,876.29 |
| 15/Jun/2026 | 180 | 3,750,938.91 | 20,560,287.16 | 24,311,226.07 | 267,283,589.13 |
| 15/Dec/2026 | 180 | 3,545,336.04 | 20,560,287.16 | 24,105,623.20 | 246,723,301.96 |
| 15/Jun/2027 | 180 | 3,339,733.17 | 20,560,287.16 | 23,900,020.33 | 226,163,014.80 |
| 15/Dec/2027 | 180 | 3,134,130.30 | 20,560,287.16 | 23,694,417.46 | 205,602,727.64 |
| 15/Jun/2028 | 180 | 2,928,527.42 | 20,560,287.16 | 23,488,814.59 | 185,042,440.48 |
| 15/Dec/2028 | 180 | 2,722,924.55 | 20,560,287.16 | 23,283,211.72 | 164,482,153.31 |
| 15/Jun/2029 | 180 | 2,517,321.68 | 20,560,287.16 | 23,077,608.84 | 143,921,866.15 |
| 15/Dec/2029 | 180 | 2,311,718.81 | 20,560,287.16 | 22,872,005.97 | 123,361,578.99 |
| 15/Jun/2030 | 180 | 2,106,115.94 | 20,560,287.16 | 22,666,403.10 | 102,801,291.83 |
| 15/Dec/2030 | 180 | 1,900,513.07 | 20,560,287.16 | 22,460,800.23 | 82,241,004.66 |
| 15/Jun/2031 | 180 | 1,694,910.20 | 20,560,287.16 | 22,255,197.36 | 61,680,717.50 |
| 15/Dec/2031 | 180 | 1,489,307.32 | 20,560,287.16 | 22,049,594.49 | 41,120,430.34 |
| 15/Jun/2032 | 180 | 1,283,704.45 | 20,560,143.17 | 21,843,847.62 | 20,560,143.17 |
| төлөх | | **214,667,543.50** | **733,660,067.12** | **948,327,610.62** | 0.00 |
| ісөн | | **214,667,543.50** | **733,660,067.12** | **948,327,610.62** | |
| эүү | | - | - | - | |

<u>ийг төлөөлж:</u>

р Дулааны сүлжээ" ТӨХК-ийн
ахирал:..................Д.Бямба-Очир

р дулааны сүлжээ" ТӨХК-ийн
тлан бодогч:..................И.Шүрэнцэцэг

<u>Зээлдэгчийг төлөөлж:</u>

"Дулааны Цахилгаан Станц-2" ТӨХК-ийн
гүйцэтгэх захирал:.................. Ү.Төмөрхуяг

"Дулааны Цахилгаан Станц-2"ТӨХК-ийн
ерөнхий нягтлан бодогч:..................М.Мандах

11

БАТЛАВ. "УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.БЯМБА-ОЧИР

БАТЛАВ, "ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-2" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Т.ТӨМӨРХУЯГ

ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ГЭРЭЭ

2012 оны 01 дугаар сарын 01-ны өдөр

Дугаар 2012/84

Улаанбаатар хот

Нэг талаас "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК /цаашид "Зээлдүүлэгч" буюу "УБДС" ТӨХК гэх/, түүнийг төлөөлж ерөнхий нягтлан бодогч И.Шүрэнцэцэг нөгөө талаас "Дулааны цахилгаан станц-2" ТӨХК /цаашид "Зээлдэгч" буюу "ДЦС-2" ТӨХК гэх/ түүнийг төлөөлж ерөнхий нягтлан бодогч М.Мандах нар Монгол Улс ба Азийн хөгжлийн банкны хооронд 1997 оны 8 дугаар сарын 11-ний өдөр байгуулагдсан Зээлийн хэлэлцээр, "Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2010 оны 72 дугаар тогтоол, "Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2006 оны 141 дүгээр тогтоол, "Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2009 оны 20 дугаар тогтоол, "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2009 оны 284 дүгээр тогтоол, "Журам батлах тухай" Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам", "Төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын 2011 оны 139 дүгээр тогтоол, "Тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Сангийн сайд, Эрдэс, баялаг, эрчим хүчний сайдын хамтарсан 2011 оны 276/300 дугаар тушаалыг тус тус үндэслэл болгон "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК, "Дулааны цахилгаан станц-2" ТӨХК-ийн хооронд 2006 оны 11 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан "Эрчим хүчний хэмнэлтийн төсөл"-ийн "1492 MON(SF)" тоот гэрээг дор дурьдсан дүн, нөхцөлөөр шинэчлэн байгуулахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2012 оны дугаар сарын -ны өдөр шинэчилэн байгуулав.

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

(А) "УБДС" ТӨХК, "ДЦС-2" ТӨХК-ийн хооронд 2006 оны 11 дүгээр сарын 10–ний өдөр байгуулсан Зээлийн гэрээнд тусгагдсан нөхцөл, болзолын дагуу зээлдүүлэгч нь зээлдэгчид 18917.82 /Арван найман мянга есөн зуун арван долоон ам.доллар найн хоёр цент/ ам.долларын зээлийг дамжуулан зээлдүүлэхийг зөвшөөрсөн.

(Б) Засгийн газрын шугамаар авсан гадаадын зээлийг эргүүлэн төлөх дотоод эх үүсвэрийг бүрдүүлэх /Зээлийн хэлэлцээрт тодорхойлсоны дагуу "Эрчим хүчний хэмнэлтийн төсөл" /цаашид "Төсөл" гэнэ/-ийг хэрэгжүүлэхэд зориулан зээлдэгчид энэ гэрээнд заасан нөхцөл болзолын дагуу зээлийн хөрөнгөнөөс дамжуулан зээлдүүлэхээр Сангийн яамнаас шийдвэрлэсэн.

(В) Зээлийн хэлэлцээр болон "Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам"-д тодорхойлогдсон нэр томъёо нь утга агуулгын хувьд тухайн баримт бичгүүдэд тодорхойлсон тэрхүү утга агуулгаа энэ Дамжуулан зээлдүүлэх гэрээнд мөн адил хадгална.

Энэ гэрээний аливаа хавсралт нь түүний салшгүй хэсэг байна.

## НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ
## ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ НӨХЦӨЛ

1.1. "УБДС" ТӨХК-аас энэ гэрээний 2 дугаар зүйлд заасан нөхцөл болзолын дагуу зээлдэгчид дамжуулан зээлдүүлсэн зээлийн төгрөгөөр илэрхийлсэн нийт дүн нь 17901933,07 /Арван долоон сая есөн зуун нэг мянган төгрөг долоон мөнгө/ төгрөг байна.

1.2. Зээлдэгчийн нэр, байнгын хаяг:

| | |
|---|---|
| "Дулааны цахилгаан станц-2" ТӨХК | |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9012001006 |
| Регистрийн дугаар: | 2664623 |
| Утасны дугаар: | 632167, факс: 632177 |
| Хаяг: | Баянгол дүүрэг, Дунд гол, 20-р хороо |

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ
## ХҮҮГИЙН ХУВЬ БОЛОН ҮНДСЭН ТӨЛБӨРИЙГ ЭРГҮҮЛЖ ТӨЛӨХ НӨХЦӨЛ

2.1 Зээлдэгч нь ашигласан зээлийн өрийн үлдэгдэлд 1998.12.15-2031.12.15 хүртэлх хугацаанд жилийн 2.00 % /хоёр хувь/–тай тэнцэх хүүг төгрөгөөр тооцож тогтоосон хугацаанд "УБДС" ТӨХК-нд төлнө.

2.2 Хүүгийн төлбөрийг хагас жил тутам буюу жил бүрийн 06 дугаар сарын 15-ны, 12 дугаар сарын 15-ний өдөр тус тус төлөх бөгөөд хүүг жилийн 360 хоногоор, сарын 30 хоногоор тооцно.

2.3 Зээлдэгч нь зээлийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн төлбөрийг хойшлуулах 8 жилийг оролцуулан 35 жилийн хугацаанд төлөх бөгөөд анхны төлбөрийг 2005 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн жил бүрийн 06 дугаар сарын 15-ны өдөр, 12 дугаар сарын 15-ны өдөр энэхүү гэрээний хавсралтад заасан төлбөрийн хуваарийн дагуу "УБДС" ТӨХК-нд төлнө.

2.4 Зээлийн хэлэлцээрт энэхүү төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа хураамж төлөх үүргийг Монгол Улс хүлээсэн бол зээлдэгч нь төлбөрийг тухайн үеийн ханшаар "УБДС" ТӨХК-нд төлөх болно.

2.5 Зээлдэгч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг "УБДС" ТӨХК-ийн Худалдаа хөгжил" –Богдхан салбар банкны 406005907 тоот төгрөгийн дансанд шилжүүлэх бөгөөд нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу дансны хуулгыг үндэслэн бүртгэл тооцоог хөтөлнө. Төлбөрийн даалгаврын зориулалт гэсэн хэсэгт зээлийн "Үндсэн өрийн төлбөр" эсвэл "Хүүгийн төлбөр" гэж тодорхой бичсэн байна.

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ
## "УБДС" ТӨХК-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Энэхүү гэрээний аливаа заалтыг харгалзахгүйгээр Зээлийн хэлэлцээрийн дагуу төсөлд зориулж хөрөнгө шилжүүлж авах "УБДС" ТӨХК-ийн эрх бүхлээр буюу хэсэгчлэн зогсох, цуцлагдах эсхүл дуусгавар болох тохиолдолд

зээлдэгчийн зээлийн хөрөнгө хүлээн авах эрх нэгэн адил зогсох, цуцлагдах эсхүл дуусгавар болно.

3.2 Зээлдэгч Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцож, үл маргалдах журмаар Зээлдэгчийн Худалдаа хөгжлийн банк дахь "458011091" тоот данснаас төлбөрийг гаргуулах эрхтэй.

3.3 Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг дор дурдсан дараалаар хасалт хийж тооцно. Үүнд:

1. Алданги
2. Хүүгийн төлбөр
3. Үндсэн төлбөр

3.4 Зээлдэгч зээлийг зориулалт бусаар ашигласан, зээлийн төлбөрийг Дамжуулан зээлдүүлэх гэрээнд заасан хугацаанд эргүүлэн төлөөгүй болон "Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам", Зээлийн хэлэлцээр, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд зээлийг хэсэгчлэн эсвэл бүрэн хэмжээгээр зогсоох, төсөл хэрэгжүүлэх эрхийг түдгэлзүүлэх, холбогдох албан тушаалтанд хариуцлага ногдуулах, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.5 Зээлдэгч гуравдагч этгээдтэй дамжуулан зээлдэх давхар гэрээ байгуулах эсэхээс үл хамааран дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг гагцхүү зээлдэгчээр төлүүлнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ
## ЗЭЭЛДЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Зээлдэгч нь энэ гэрээний Ерөнхий зүйлийг (Б)-д заасан төслийг удирдлага, зохион байгуулалт, санхүү, инженер техник, байгаль орчин болон олон улсын стандартын хэм хэмжээний хүрээнд үр ашигтай хэрэгжүүлэх үүрэгтэй.

4.2 Зээлдэгч нь Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон хөрөнгийг зөвхөн Зээлийн хэлэлцээрт заасан төслийн зориулалтаар ашиглана.

4.3 Зээлийн данснаас шилжүүлсэн төлбөрийг хүлээн авах тухай бүрт бодитоор гарсан зардлын үндсэн баримтыг үндэслэн бүртгэл тайланд тусгана.

4.4 Зээлдэгчийн зээлийн хөрөнгөөр авсан эд хөрөнгө нь төрийн өмчид хамаарах бөгөөд Дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болох хүртэл тайлан тэнцэлдээ өглөг хэлбэрээр тусгаж бүртгэнэ.

4.5 Зээлдэгч нь зээлийн хөрөнгөөр олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй бөгөөд эд хөрөнгийг захиран зарцуулахыг хориглоно.

4.6 Зээлдэгч нь үндсэн болон хүүгийн төлбөр хийсэн тухай бүр "УБДС" ТӨХК-нд мэдэгдэж улирал бүр тооцоо нийлж баталгаажуулах үүрэгтэй.

4.7 Хэрэв зээлдэгч үүсгэн байгуулсан зорилтот үйл ажиллагаагаа зогсоох, татан буугдах зэрэг тохиолдолд дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн өрийн төлөгдөөгүй үлдэгдэл, тухайн үед хуримтлагдсан бүх хүүг нэн даруй "УБДС" ТӨХК-нд төлнө.

4.8 Зээлдэгч дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалтын явцын талаарх тайлан танилцуулгыг хагас, бүтэн жилээр гаргаж, зээлийн шугамаар нийлүүлэгдэх тоног, төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалыг хүлээн авсан нийлүүлэлт, үлдэгдлийн мэдээ, тайланг тухай бүр зээлдэгчид ирүүлнэ.

## ТАВДУГААР ЗҮЙЛ
## МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

5.1 Сангийн яам, зээлдэгчийн хооронд гарсан аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд хэрэв ийм шугамаар шийдвэрлэх боломжгүй бол маргааныг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

## ЗУРГААДУГААР ЗҮЙЛ
## ХҮЧИН ТӨГӨЛДӨР, ДУУСГАВАР БОЛОХ

Энэхүү шинэчилсэн гэрээ нь оролцогч талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

Сангийн яам холбогдох яам, газартай энэхүү гэрээг дүгнэж, зээлдэгч уг зээлтэй холбогдох ямар нэг өр төлбөргүй болохыг тодорхойлсон эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргаж, зээлийг хаасан тухай Сангийн яамны мэдэгдлийг зээлдэгчид хүргүүлсэнээр уг Дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болсонд тооцно.

Зээлдэгч нь өөрчлөн байгуулагдах тохиолдолд зээлдэгчийн Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг нь ийнхүү өөрчлөн байгуулагдсаны дүнд шинээр үүссэн хуулийн этгээдэд шилжинэ.

Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа дамжуулан зээлдүүлсэн зээлийн өр төлбөрийг тайлан балансад зайлшгүй тусгана.

Энэ гэрээ байгуулсантай холбогдуулан зээлдэгч, зээлдүүлэгчийн хооронд өмнө нь байгуулагдсан дараахь гэрээнүүдийг хүчингүй болсонд тооцно. Үүнд:

- "УБДС" ТӨХК, "ДЦС-2" ТӨХК-ын хооронд оны 2004 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байгуулагдсан 1492 MON(SF) дугаартай "Эрчим хүчний хэмнэлтийн төсөл"-ийн дамжуулан зээлдэх гэрээ";
- "УБДС" ТӨХК, "ДЦС-2" ТӨХК-ын хооронд 2006 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр байгуулагдсан 1492 MON(SF) дугаартай "Эрчим хүчний хэмнэлтийн төсөл"-ийн дамжуулан зээлдэх гэрээ";
- "УБДС" ТӨХК, "ДЦС-2" ТӨХК-ын хооронд 2010 оны 10 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан "2006 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр "УБДС" ТӨХК ба "УБЦТС" ТӨХК-ын хооронд байгуулсан 1492 MON(SF) тоот Дамжуулан зээлдүүлэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ".

| **САНГИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ:** | **ЗЭЭЛДЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** |
| --- | --- |
| "УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ | "ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-2" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ |
| И.ШҮРЭНЦЭЦЭГ | М.МАНДАХ |

-ын 2010 оны 72 дугаар тогтоолын хүрээнд Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК болон Дулааны
Цлгаан Станц-2 ТӨХК-ийн хооронд байгуулсан 1492-MON(SF) дугаартай дамжуулан зээлдүүлэх
гэрээний хавсралт

ін эргэн төлөх хуваарь

Хүү 2%

| *Тайлант хугацаа* | *Хоног* | *Хүүгийн төлбөр/төг/* | *Үндсэн төлбөр* | *Нийт* | *Зээлийн үлдэгдэл* |
|---|---|---|---|---|---|
| 15/Dec/2011 | 180 | | | 0.00 | 15,249,794.83 |
| 15/Jun/2012 | 180 | 174129.45 | 381244.87 | 555374.32 | 14,868,549.97 |
| 15/Dec/2012 | 180 | 170317.00 | 381244.87 | 551561.87 | 14,487,305.10 |
| 15/Jun/2013 | 180 | 166504.55 | 381244.87 | 547749.42 | 14,106,060.23 |
| 15/Dec/2013 | 180 | 162692.10 | 381244.87 | 543936.97 | 13,724,815.36 |
| 15/Jun/2014 | 180 | 158879.65 | 381244.87 | 540124.52 | 13,343,570.49 |
| 15/Dec/2014 | 180 | 155067.20 | 381244.87 | 536312.07 | 12,962,325.62 |
| 15/Jun/2015 | 180 | 151254.76 | 381244.87 | 532499.63 | 12,581,080.75 |
| 15/Dec/2015 | 180 | 147442.31 | 381244.87 | 528687.18 | 12,199,835.88 |
| 15/Jun/2016 | 180 | 143629.86 | 381244.87 | 524874.73 | 11,818,591.01 |
| 15/Dec/2016 | 180 | 139817.41 | 381244.87 | 521062.28 | 11,437,346.14 |
| 15/Jun/2017 | 180 | 136004.96 | 381244.87 | 517249.83 | 11,056,101.28 |
| 15/Dec/2017 | 180 | 132192.51 | 381244.87 | 513437.38 | 10,674,856.41 |
| 15/Jun/2018 | 180 | 128380.06 | 381244.87 | 509624.93 | 10,293,611.54 |
| 15/Dec/2018 | 180 | 124567.62 | 381244.87 | 505812.48 | 9,912,366.67 |
| 15/Jun/2019 | 180 | 120755.17 | 381244.87 | 502000.04 | 9,531,121.80 |
| 15/Dec/2019 | 180 | 116942.72 | 381244.87 | 498187.59 | 9,149,876.93 |
| 15/Jun/2020 | 180 | 113130.27 | 381244.87 | 494375.14 | 8,768,632.06 |
| 15/Dec/2020 | 180 | 109317.82 | 381244.87 | 490562.69 | 8,387,387.19 |
| 15/Jun/2021 | 180 | 105505.37 | 381244.87 | 486750.24 | 8,006,142.32 |
| 15/Dec/2021 | 180 | 101692.92 | 381244.87 | 482937.79 | 7,624,897.45 |
| 15/Jun/2022 | 180 | 97880.47 | 381244.87 | 479125.34 | 7,243,652.59 |
| 15/Dec/2022 | 180 | 94068.03 | 381244.87 | 475312.89 | 6,862,407.72 |
| 15/Jun/2023 | 180 | 90255.58 | 381244.87 | 471500.45 | 6,481,162.85 |
| 15/Dec/2023 | 180 | 86443.13 | 381244.87 | 467688.00 | 6,099,917.98 |
| 15/Jun/2024 | 180 | 82630.68 | 381244.87 | 463875.55 | 5,718,673.11 |
| 15/Dec/2024 | 180 | 78818.23 | 381244.87 | 460063.10 | 5,337,428.24 |
| 15/Jun/2025 | 180 | 75005.78 | 381244.87 | 456250.65 | 4,956,183.37 |
| 15/Dec/2025 | 180 | 71193.33 | 381244.87 | 452438.20 | 4,574,938.50 |
| 15/Jun/2026 | 180 | 67380.89 | 381244.87 | 448625.75 | 4,193,693.63 |
| 15/Dec/2026 | 180 | 63568.44 | 381244.87 | 444813.31 | 3,812,448.76 |
| 15/Jun/2027 | 180 | 59755.99 | 381244.87 | 441000.86 | 3,431,203.90 |
| 15/Dec/2027 | 180 | 55943.54 | 381244.87 | 437188.41 | 3,049,959.03 |
| 15/Jun/2028 | 180 | 52131.09 | 381244.87 | 433375.96 | 2,668,714.16 |
| 15/Dec/2028 | 180 | 48318.64 | 381244.87 | 429563.51 | 2,287,469.29 |
| 15/Jun/2029 | 180 | 44506.19 | 381244.87 | 425751.06 | 1,906,224.42 |
| 5/Dec/2029 | 180 | 40693.74 | 381244.87 | 421938.61 | 1,524,979.55 |
| 15/Jun/2030 | 180 | 36881.30 | 381244.87 | 418126.16 | 1,143,734.68 |
| 5/Dec/2030 | 180 | 33068.85 | 381244.87 | 414313.72 | 762,489.81 |

17

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15/Jun/2031 | 180 | 29256.40 | 381244.87 | 410501.27 | 381,244.94 |
| 15/Dec/2031 | 180 | 25443.95 | 381244.94 | 406688.89 | 0.00 |
| | | **10,858,596.72** | **17,901,933.06** | **28,760,529.78** | |

...эгчийг төлөөлж:

...аатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн
...х захирал.....................Д.Бямба-Очир

...аатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн
...нягтлан бодогч:...................И.Шүрэнцэцэг

Зээлдэгчийг төлөөлж:

"Дулааны Цахилгаан Станц-2" ТӨХК-ийн
гүйцэтгэх захирал:..................... Ү.Төмөрхуяг

"Дулааны Цахилгаан Станц-2"ТӨХК-ийн
ерөнхий нягтлан бодогч:.....................М.Мандах

## ДУЛААНЫ ҮР АШГИЙН ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР

Улаанбаатар хотын дулааны үр ашгийн төсөл нь Азийн Хөгжлийн банкы санхүүжилтээр 2001-2003 онуудад хэрэгжсэн. Төслийг хэрэгжүүлэгч байгууллага захиалагч нь ЭХУГ, УБДС ХК, төслийн багц 1 –н гүйцэтгэгч нь БНХАУ –н БЕРИС компани. Дулааны үр ашгийн төслийн хүрээнд ДЦС-2 ХК –н дотоод хэрэгцээний халаалтын сүлжээг тусгаарлах ажил хийгдсэн. Тоноглолын нийт үнэ нь 503721,31 зээлжих тусгай эрх бөгөөд зээлийн гэрээ нь 20 жилийн хугацаатай, зээлийн хүү 5%-тайгаар анх байгуулагдсан бөгөөд нийт 3 удаа зээлийн гэрээнд өөрчлөлт орсон ба хамгийн сүүлд УИХ-ын 2010 оны 72-р тогтоол, "Тогтоол хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" Сангийн сайд, Эрдэс баялаг эрчим хүчний сайдын хамтарсан 2011 оны 276/300 дугаар тушаалыг үндэслэл болгон урт хугацаат дамжуулан зээлдүүлэх гэрээг валютаас төгрөгт шилжүүлэн гэрээг шинэчлэн хийж, 2012 оны 4 сараас эхлэн мөрдөн ажиллаж байна. Ингэснээр энэхүү төслийн зээлийн төлбөрийн үлдэгдэл 723,0 сая төг-ийг 2032 оныг дуустал төлж барагдуулах юм.

**Энэхүү төслийн хүрээнд:**

- ✓ 7,2 мВт –н хүчин чадалтай сүлжээний усны халаагч 2ш,
- ✓ 80 т/ц –н бүтээмжтэй дотоод сүлжээний усны насос 3ш,
- ✓ 16 м3/ц –н бүтээмжтэй конденсатын насос 3ш,
- ✓ 6 м3/ц –н бүтээмжтэй нэмэлт усны насос 3ш,
- ✓ Холбогдох фильтрүүд, уур усны шугам хоолой хаалт арматурууд, хамгаалах, хэмжих хэрэгслэлүүд,
- ✓ РН –н хэмжээг тохируулах дозон систем, сүлжээний усны даралт, температур, зарцуулалтыг хэмжээ болон насос, хаалтнуудын ажиллагааг хянаж удирдах автомат удирдлагын системийг тус тус суурилуулсан.

**Төслийн үр дүн нь:**

- ✓ Станцын дотоод сүлжээний өгөх буцах усны даралтын зөрүү ихсэж, халууныг автоматаар тохируулсанаар халаалт сайжирсан.
- ✓ Босоо хэлбэрийн насос, бөмбөлгөн хаалт, регуляторууд, элекрон тоолуурууд зэрэг сүүлийн үеийн дэвшилттэй найдвартай ажиллагаатай тоноглолууд суурилагдсан ашиглалтанд орсоноос хойш эвдрэл гэмтэлгүй ажиллаж байна.
- ✓ Дотоод халаалтын сүлжээг тусгаарласнаар УБДС ХК –тай усны алдагдал, химийн горимын талаар гарах маргаангүй болсон.
- ✓ Дотоод халаалтын системийг тусгаарласнаар үндсэн сүлжээнээс хэрэглэгчид түгээх усны хэмжээ 180 тн/ц, жилдээ 8436 Гкал –р нэмэгдэж борлуулалт өссөн.

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР

Улаанбаатар хотын эрчим хүчний хэмнэлтийн төсөл нь Азийн Хөгжлийн банкы санхүүжилтээр 1997-2002 онуудад хэрэгжсэн. Төслийг хэрэгжүүлэгч байгууллага захиалагч нь ЭХУГазар. Тоноглолын нийт үнэ нь 18878,1 зээлжих тусгай эрх бөгөөд мөн нийт 3 удаа зээлийн гэрээнд өөрчлөлт орсон ба хамгийн сүүлд УИХ-ын 2010 оны 72-р тогтоол, "Тогтоол хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" Сангийн сайд, Эрдэс баялаг эрчим хүчний сайдын хамтарсан 2011 оны 276/300 дугаар тушаалыг үндэслэл болгон урт хугацаат дамжуулан зээлдүүлэх гэрээг валютаас төгрөгт шилжүүлэн гэрээг шинэчлэн хийж, 2012 оны 4 сараас эхлэн мөрдөн ажиллаж байгаа ба энэхүү төслийн зээлийн үлдэгдэл 14,9 сая төг-ийг 2031 оны 12 сард төлж дуусах юм.

**Энэхүү төслийн хүрээнд:**

- ✓ 35 кв-ын гүйдлийн трансформатор 2ш,
- ✓ Куантун тоолуур 2ш,
- ✓ Вектрон тоолуур 18ш тоолуурыг тус тус суурилуулсан байна.

**Эрчим хүчний төсөлөөр хэрэгжүүлсэн ажлын үр дүн :**

- ✓ Хуучин механик тоолууртай байх үед гардаг байсан механик гэмтэл бүрэн байхгүй болсон.
- ✓ Тоолуурын нарийвчлалын анги дээшилж тоолуурын алдаа багассан.
- ✓ Бүх электрон тоолуурыг сүлжээ үүсгэн хяналтын систем үүсгэх боломжтой болсон.
- ✓ Боловсруулалт түгээлтийн тооцоо хийхэд хялбар болсон.

## САНГИЙН ЯАМАНД ТӨЛӨХ ЗЭЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР

2001 оноос өмнө буюу тус станц хувьцаат компани болохоос өмнө Түүхий эд бараа материалыг Төвийн эрчим хүчний системийн хангамжийн хэлтэс гүйцэтгэж бэлтгэдэг байсан. Энэ үед бэлтгэгдэн орлого ороод, өглөг үүссэн бараа материалаас СЭЗЯамны тусламжийн орлогын санд төвлөрүүлэх бараа гэж салган урт хугацаат өр үүсгэсэн юм. Анхны гэрээгээр 257,0 сая төг-ийн орлого төвлөрүүлэх графиктай байсан өнөөдрийн байдлаар 188,0 сая төг-ийг төвлөрүүлэх үлдэгдэлтэй байна.